

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023.12.27

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт, үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/ | Суурь түвшин | Зорилтод хүрэх түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|--|--|--|------------------|--------------------------------|------------------|------------------------------------|---|--|--------|-------------------|---|-------------------|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Түвшин | Төсвийн гүйцэтгэл | | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 3.1. Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | | | | | | | | | | | | |
| 2.1.21 | НХТЖҮЧ 4.1.3 НЗДҮАХ-3.1.4 | Нийслэлийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг улсын нэгдсэн мэдээллийн системтэй уялдуулан нэвтрүүлнэ. | 2023 | НЗДТГ-ын ХБТХ НЦХМТГ | Нийслэлийн төсөв | 300.0 | - | 100 | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 15 дугаар хуралдааны тэмдэглэлээр Төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/ системтэй ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг үүрэг болгосны дагуу тус ажил хийгдэх боломжгүй болсон болно. | 0% |
| 3.1.2 | НХТЖҮЧ 5.3.2 НЗДҮАХ 4.1.1 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал www.e-mongolia.mn системд холбоно. | 2023 | НЦХМТГ НЗДТГ-ТЗУХ, НҮНТ | Нийслэлийн төсөв | - | 29 байгууллагын 256 нэр төрлийн үйлчилгээ | 35 байгууллагын 320 нэр төрлийн үйлчилгээ болгон нэмэгдүүлсэн байна. | - | - | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлдэг төрийн үйлчилгээг цахимжуулах хүрээнд “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-д 2023 онд Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны 29, Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2, нийслэлийн Онцгой байдлын газар 2, 9 дүүргийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн 9 үйлчилгээ буюу нийт 42 үйлчилгээг цахимжуулсан. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн | 70% |

| | | | | | | | | | | | |
|--------|------------------------------------|---|------|--------|------------------|-------|-----|-----|---|---|-----|
| | | | | | | | | | | <p>портал www.e-mongolia.mn систем, түүний дэд систем болох "E-Business" платформуудад Нийслэлийн "Онлайн бизнес төв" системээр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нутгийн захиргааны 10 байгууллагын нийт 86 үйлчилгээг холбосон. Ингэснээр 3 эх үүсвэрээр иргэн аж ахуй нэгж байгууллагаас хүсэлтийг хүлээн авдаг болсон. Энэхүү төслийн төсөв нь "Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно.</p> | |
| 3.1.10 | НХТЖҮЧ 5.2.3 НЗДҮАХ 4.1.3 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын "UB ERP" системийг гар утасны аппликейшны нэмэлт хөгжүүлэлтийг хийнэ. | 2023 | НЦХМТГ | Нийслэлийн төсөв | 300.0 | 50% | 90% | - | <p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн UBERP системийг нийслэлийн 1250 байгууллагын 28,400 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж албан бичгийг 100% цахимаар солилцож байна. "UB ERP" системийн гар утасны аппликейшны хөгжүүлэлтийн техникийн даалгаврыг боловсруулан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч "Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно.</p> | 70% |

| | | | | | | | | | | | | |
|------------|------------------------------------|---|------|--------------------------------|-------------------------|-------|-----|-----|---|--|--|------|
| 3.1.1 1 | НХТЖҮЧ 5.3.3 НЗДҮАХ 4.1.3 | "Call center" дуудлагын төвийг өргөжүүлнэ. | 2023 | НЦХМТГ | Нийслэл ийн төсөв | 220.0 | 50% | 70% | - | | Нийслэлийн лавлагаа мэдээллийн төв буюу Call center дуудлагын төв 1800-1200 тусгай дугаарт Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв, нийслэлийн Тээврийн үйлчилгээний газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Ус сувгийн удирдах газар, ОСНААУГ ОНӨААТҮГ-уудын тусгай дугааруудыг холбон 7/24 цагийн горимоор ажилладаг. "Call center" дуудлагын төвийг өргөжүүлэх тус төсөл, арга хэмжээний техникийн даалгаврыг боловсруулан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж худалдан авах ажиллагааг зарласан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосонтой холбоотой хэрэгжүүлэх боломжгүй болсон. | 70% |
| 3.1.1 2 | НХТЖҮЧ 5.3.3 НЗДҮАХ 4.1.3 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд ашиглагдаж буй цахим технологи, програм хангамжийн бүртгэл, эрх, аюулгүй ажиллагааны журам | 2023 | НЗДТГ-ын ТЗУХ НЦХМТГ | - | - | 1 | | | | Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага дотооддоо Мэдээллийн аюулгүй байдлын журам боловсруулан мөрдөн ажиллаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, албан хэрэглээний компьютер болон дагалдах тоног төхөөрөмжүүдийг гадна | 100% |


| | | | | | | | | | | | | |
|---|--------------------------------------|--|------|--------|-------------------|---------|---|------|---|--|---|-----|
| | | боловсруулж, батлуулна. | | | | | | | | | дотны халдлагаас хамгаалах, нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хадгалах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, сүлжээ, серверийн хэвийн найдвартай ажиллагааг хангах нийслэлийн Дата төвд зориулалт бүхий 12 рак, 88 физик сервер, 176 виртуал сервер, хадгалах төхөөрөмж, 130 систем, 278 цахим хуудасны мэдээлэл байрладаг бөгөөд тэдгээрийн хэвийн найдвартай байнгын горимоор тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. | |
| 6.1 Авто замын хөдөлгөөний төлөвлөлтийг оновчтой түвшинд төлөвлөж, авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулна. | | | | | | | | | | | | |
| 6.1.15 | НХТЖҮЧ 9.20.2 НЗДҮАХ 6.3.11 | Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем нэвтрүүлнэ. | 2023 | НЦХМТГ | Нийслэл ийн төсөв | 7,435.0 | - | 100% | - | | Нийслэлийн авто замын гэрлэн дохиотой 161 уулзварт "Г" хэлбэрийн 343 шон, 14 байршилд "П" хэлбэрийн шон суурилуулж тухайн байршлуудад болон нийслэлийн харьяа 7 шалган бүртгэх товчоод, оношилгооны 5 төвд нийт 455 радио давтамж тодорхойлох /RFID/ уншигч төхөөрөмж, 1036 уншигч антенн 2022 онд бүрэн суурилуулсан. Радио давтамж тодорхойлох RFID системийг хэрэглээнд нэвтрүүлэх дэд бүтцийн ажил бүрэн хангагдсан бөгөөд улсын хэмжээнд 1,201,991 тээврийн хэрэгслүүдэд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ суурилуулах, түүнчлэн цахим гэрчилгээг унших Радио давтамж | 70% |

| | | | | | | | | | | | |
|---|--|--|--|--|--|--|--|--|--|---|--|
| | | | | | | | | | | <p>тодорхойлох RFID системийг нэвтрүүлэх ажлуудыг Зам, тээврийн хөгжлийн яам зохион байгуулж байгаа бөгөөд Нийслэлийн хэмжээнд 442,477 тээврийн хэрэгсэлд суурилуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Авто тээврийн хэрэгслийн техникийн цахим гэрчилгээ /RFID tag/-г нийслэлийн хэмжээнд 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 44 цэгээр дамжуулан 88 ажилтан албан хаагчид 442,477 ширхэг цахим гэрчилгээг тээврийн хэрэгслүүдэд суурилуулахаар төлөвлөснөөс 2023 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн байдлаар төрийн 87 байгууллагын нийт 2298 тээврийн хэрэгсэлд цахим гэрчилгээ /RFID tag/-г нааж суурилаад байна.</p> | |
| ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ: | | | | | | | | | | 76% | |
| <p>Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 6 арга хэмжээнээс 100 хувьтай хэрэгжсэн <u>1</u> арга хэмжээ 70 хувьтай хэрэгжсэн <u>4</u> арга хэмжээ Хэрэгжилт гарах боломжгүй <u>1</u> арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж 76%-тай байна.</p> | | | | | | | | | | | |

ТАНИЛЦСАН:
ДАРГА

 Б.ДАВААНЯМ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.САЙНХҮҮ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Т.ОТГОНЖАРГАЛ